2021 оны 05 сарын 12-ны өдөр Дугаар А/362 Улаанбаатар хот

Нийслэлийн төр, захиргааны
байгууллагуудын ажлын цагийн хуваарьт
зохицуулалт хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6.”к”, 29.2, 29.3, Засгийн газрын 2014 оны 393 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэлийн авто замын ачааллыг бууруулах зорилгоор энэ захирамжийн хавсралтад заасан нийслэлийн төр, захиргааны байгууллагын ажил эхлэх цагийг 2021 оны 05 дугаар сарын 17-ны өдрөөс 08 дугаар сарын 31-ний өдрийн хооронд 08 цаг 00 минут, бусад хугацаанд ажил эхлэх цагийг 09:00 цаг байхаар тогтоосугай.

2.Энэ захирамжийн хэрэгжилтийг хангаж, биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (Т.Оюунчимэг), хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж сурталчлахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэлтэй харилцах хэлтэс (Г.Хонгорзул)-т үүрэг болгосугай.

3.Энэ захирамж гарсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/417 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ Д.СУМЪЯАБАЗАР

Нийслэлийн Засаг даргын 2021 оны
05 дугаар сарын 12-ны өдрийн
А/362 дугаар захирамжийн хавсралт

АЖЛЫН ЦАГИЙН ХУВААРЬТ ЗОХИЦУУЛАЛТ ХИЙХ НИЙСЛЭЛИЙН ТӨР, ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУДЫН ЖАГСААЛТ

д/д	Байгууллага
1	Нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба
2	Нийслэл, дүүрэг (Хороо)-ийн Засаг даргын Тамгын газар
3	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, харьяа газар
4	Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг
5	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар (хуулийн этгээд, байгууллага)